



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 254/А/1240315

Мандалговь

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар сангийн хөрөнгийг зураг төсөвгүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар 221,000,000.00 /Хоёр зуун хорин нэгэн сая/ төгрөгийг төлөвлөж баталсан зөрчил илэрлээ. /Халуун усны засвар – 35.0 сая, ЭКО ОО барих- 35.0 сая, Сумын төвийг камержуулах – 6.0 сая, Малын хөлийн албан татварын орлогоос санхүүжих төсөл арга хэмжээ -145.0 сая /

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.4.1-д /Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;/ , 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1-д /орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.3.3.-т /ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх, хууль журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Адаацаг сумын Засаг дарга

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

Ч.Уранчимэг, Засаг даргын орлогч Х.Нямцэцэг, Санхүүгийн албаны дарга Э.Баяржаргал, нягтлан бодогч Ө.Уранбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

ДИХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

